



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/141

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн “Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Боржигин өв соёлын танхимтай болох үзмэрийг баяжуулах” ажлын санхүүжилтэнд 5000000 (таван сая) төгрөгийг зарцуулсугай.
2. “Боржигин өв соёлын танхимтай болох үзмэрийг баяжуулах” ажлын санхүүжилтэнд 5000000 (таван сая) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (М.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.
3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ